



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 4 сарын 16 өдөр

Дугаар 756

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2, 4.4 дахь заалт, "Мэдээ тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалт, 2023 оны "Тогтоолын нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 467 тогтоолын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Онцгой байдлын ерөнхий газрын харьяа ар талын 115 дугаар ангийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 4 нэрийн нийт 29,457,640.00 (хорин есөн сая дөрвөн зуун тавин долоон мянга зургаан зуун дөч) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Г.Ариунбуян, Ар талын 115 дугаар ангийн захирагч хурандаа Л.Баярсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Төрийн өмчийн төлөөлөгчийг оролцуулан үндсэн хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдаанаас олох орлогыг (холбогдох зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4.Автомашиныг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ


ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132003062

31-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн
756 дугаар тогтоолын хавсралт



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭРГЭДЭХ АР ТАЛЫН 115 ДУГААР
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР
ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ, ХУДАЛДАХ ДООД ҮНЭ

д/д	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн/ ашиглалтад орсон он	тоо хэмжээ	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
1	Зил-130 усны /51-70 УБЦ/	1996/1996	1	1,736,640.00	1,500,000.00
2	Соната-5 /06-03 УБГ/	2004/2005	1	10,454,000.00	2,000,000.00
3	Тоёота Хариэр /08-84 УНБ/	2000/2011	1	8,000,000.00	4,000,000.00
4	Хьюндай Санта-Фе /72- 01 УБЭ/	2007/2007	1	9,267,000.00	5,000,000.00
Нийт дүн			4	29,457,640.00	12,500,000.00
				(хорин есөн сая дөрвөн зуун тавин долоон мянга зургаан зуун дөч)	(арван хоёр сая таван зуун мянга)